

ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдэд тусгагдсан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зүйл заалтуудын хэрэгжилтэд 2024 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон Сангийн яамны хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудын хэрэгжилтийн явцын тайлан, холбогдох мэдээ, мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээг гүйцэтгэж, үр дүнд үнэлгээ хийлээ.

Холбогдох эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаа үйлчлэх шинж чанартай бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр үнэлгээг тооцож гаргасан болно.

Сангийн яам Монгол Улсын хуулийн 31, Улсын Их Хурлын тогтоолын 44, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 43, Ерөнхийлөгчийн зарлигт тусгагдсан 3, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид тусгагдсан 4, Засгийн газрын тогтоолд тусгагдсан 132, Ерөнхий сайдын захирамжид тусгагдсан 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 95, Засгийн газрын албан даалгаварт тусгагдсан 3 нийт 785 зүйл заалтыг хяналтад авч ажиллав. 2024 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт **92.04 хувьтай** байлаа.